

# САНХҮҮГИЙН БУС БИЗНЕС, МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН 2022 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ТОЙМ

---


ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛ, ҮНЭТ  
ЭДЛЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

# ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧ

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Тайлант улирлын байдлаар нийт 456 иргэн, 45 хуулийн этгээдэд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооноос олгосон байна.

Хөдөө, орон нутаг  
18.6%




Улаанбаатар  
81.4%

Тус салбарт үйл ажиллагаа эрхэлж буй нийт тусгай зөвшөөрөлтэй арилжаа эрхлэгчдийн 81.4 хувь нь Улаанбаатар хотод, үлдсэн 18.6 хувь нь хөдөө, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна.

## Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээд


Тайлант улиралд нийт 45 хуулийн этгээдэд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооноос олгосон бөгөөд арилжаа эрхлэгч хуулийн этгээдийн 44 буюу 97.7 хувь нь Улаанбаатар хотод голчлон үйл ажиллагаа эрхэлж байна.



ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ


Тайлант улиралд тусгай зөвшөөрөлтэй 45 хуулийн этгээдийн 75 хувьцаа эзэмшигчдийн нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 9.4 тэрбум төгрөг байна.

## УЛААНБААТАР ХОТОД



## Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэд

Тайлант улиралд нийт 456 иргэнд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооноос олгосон байна. Үүнээс, үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 251 иргэн, үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч 136 иргэн, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 69 иргэн тус тус бүртгэлтэй байна.




### УЛААНБААТАР ХОТОД


### ХӨДӨӨ, ОРОН НУТАГТ

Нийт тусгай зөвшөөрөлтэй арилжаа эрхлэгч иргэдийн 364 буюу 79.8 хувь нь Улаанбаатар хотод, үлдсэн 92 буюу 20.2 хувь нь хөдөө, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна.


### Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэд



### Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч



### Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч



## ХУДАЛДАЖ, ХУДАЛДАН АВСАН ҮНЭТ МЕТАЛЛЫН ДҮН:

Тайлант хугацаанд 1.2 тонн алтыг 216.3 тэрбум төгрөгөөр худалдан авч, 1.4 тонн алтыг 213.1 тэрбум төгрөгөөр борлуулсан нь өмнөх оны мөн үеэс худалдан авсан алтны хэмжээ 46.5 хувиар, худалдсан алтны хэмжээ 54.1 хувиар буурсан байна.

### ХУДАЛДСАН

АЛТ

МӨНГӨ

213.1 ТЭРБУМ  
ТӨГРӨГ

214.2 САЯ  
ТӨГРӨГ



### ХУДАЛДАН АВСАН

АЛТ

МӨНГӨ

216.3 ТЭРБУМ  
ТӨГРӨГ

153.2 САЯ  
ТӨГРӨГ



## ХУДАЛДАЖ, ХУДАЛДАН АВСАН ҮНЭТ ЭДЛЭЛИЙН ДҮН:



Үнэт эдлэлийн борлуулалтын И-Баримтын мэдээгээр 2022 оны 3 дугаар улиралд давхардсан тоогоор 410 үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэн, хуулийн этгээд нь 6,651 харилцагчид 24,830 бүтээгдэхүүнийг 5.1 тэрбум төгрөгөөр худалдан борлуулсан байна.

## ХАМТЫН АЖИЛЛАГАА

“Гар урлалыг сэргээх, сурталчлах бодлого, арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах” ажлын хэсэгт орж, Соёлын яамтай хамтран ажилласан.

01

Бичил уурхай эрхлэгчдийг албажуулах, алтны гарал үүслийг тодорхойлох, нийлүүлэлтийн сүлжээг ил тод болгох ажлын хүрээнд The PlanetGold төслийн Монгол Улс дахь суурин төлөөлөгчидтэй 2022 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр хамтарсан уулзалтыг зохион байгуулж, бичил уурхайн үйл ажиллагааг хариуцлагажуулах, бичил уурхайчдын амьжиргааны байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, сайн туршлага бий болгоход хамтран ажиллахаар санал солилцсон.

02

Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудад “Алтны бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээтэй танилцах” үзлэг, хэлэлцүүлгийг The PlanetGold төсөл болон холбогдох төрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.

03


Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо, Азийн сангийн дэмжлэгтэйгээр зохион байгуулагдсан уул уурхайн салбарт бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй нэгжүүдийн мэдээллийн санг бүрдүүлэх зорилгоор “Хууль бус олборлолттой тэмцэх чадавхыг бэхжүүлэх” төслийг хэлэлцүүлэгт оролцож, санал солилцсон.

04

# ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГА

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Тайлант улиралд нийт 295 хуулийн этгээдэд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооноос олгосон байна.



ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ


Тусгай зөвшөөрөлтэй үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагуудын 446 хувьцаа эзэмшигчдийн нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 6.1 тэрбум төгрөг байна

## БРОКЕР, АГЕНТЫН МЭДЭЭЛЭЛ

Нэг үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага дунджаар 1 брокер, 5 агенттайгаар ажиллаж байна. Хамгийн олон агенттай үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын агентын тоо 81 байна.


### БРОКЕР

309




### АГЕНТ

1,413



## УЛААНБААТАР ХОТОД


ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ 86 ҮХЭХЗБ БУЮУ 29.5 ХУВЬ НЬ СҮХБААТАР, 78 ҮХЭХЗБ БУЮУ 26.7 ХУВЬ НЬ ХАН-УУЛ, 36 ҮХЭХЗБ БУЮУ 12.3 ХУВЬ НЬ ЧИНГЭЛТЭЙ, 52 ҮХЭХЗБ БУЮУ 17.8 ХУВЬ НЬ БАЯНЗҮРХ, 34 ҮХЭХЗБ БУЮУ 11.6 ХУВЬ НЬ БАЯНГОЛ, 6 ҮХЭХЗБ БУЮУ 2 ХУВЬ НЬ СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГТ ТУС ТУС ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БАЙГАА БОЛ ХӨДӨӨ, ОРОН НУТАГТ 3 ҮХЭХЗБ БУЮУ 1 ХУВЬ НЬ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БАЙНА.




## ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ, ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Давхардсан тоогоор ҮХЭХЗ-ын байгууллага нийт 5469 хэлцлээр, 1.4 сая м.кв талбай, 927.5 тэрбум төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг зуучлан худалдан, шилжүүлжээ.

**Шимтгэлийн хувь / Борлуулсан хэлцлийн тоогоор/**




**Талбайн хэмжээ /Борлуулсан хэлцлийн тоогоор/**




## ТҮРЭЭСЛЭХ, ТҮРЭЭСЛҮҮЛЭХ, ХӨЛСЛӨХ, ХӨЛСЛҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Тайлант хугацаанд нийт 3,209 хэлцлээр 293.0 мянган м.кв талбай, 86.1 тэрбум төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг зуучлан хөлслүүлж, түрээслүүлжээ.

**Шимтгэлийн хувь / Түрээсэлсэн хэлцлийн тоогоор/**



**Талбайн хэмжээ / Түрээсэлсэн хэлцлийн тоогоор/**



## ХАМТЫН АЖИЛЛАГАА

Үл хөдлөх хөрөнгийн мэдээллийн санг үүсгэх ажлын хүрээнд Барилга хот байгуулалтын яамтай 2022 оны 3 дугаар сарын 24 болон 5 дугаар сарын 10-ны өдөр тус тус уулзалт зохион байгуулж, БХБЯ-ны хэрэгжүүлж буй “Орон сууцны мэдээллийн нэгдсэн портал”-аар дамжуулан ҮХХЗ-ын салбарын холбогдох мэдээ, мэдээллийг авах нөхцөлийг бүрдүүлсэн.

01

Үндэсний үл хөдлөх хөрөнгийн хөгжлийн нийгэмлэг болон Санхүүгийн боловсрол, сургалтын албатай хамтарсан уулзалтыг 2022 оны 9 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгуулж, үл хөдлөх хөрөнгийн салбарын нэр томъёог бий болгох, үл хөдлөх хөрөнгө зуучлагчдыг мэргэшүүлэх сургалтыг сайжруулах боломжийн талаар санал солилцсон.

02

“Үл хөдлөх хөрөнгө зуучлагчдын бизнес эрхлэгчдийн нэгдсэн дээвэр холбоо” ГҮТББ, “АНР-Үл хөдлөх хөрөнгө зуучлагчдын нэгдсэн холбоо” ГҮТББ, Үндэсний үл хөдлөх хөрөнгийн хөгжлийн нийгэмлэг болон Санхүүгийн боловсрол, сургалтын албатай хамтарсан уулзалтыг 2022 оны 9 дүгээр сарын 02-ны өдөр зохион байгуулж, үл хөдлөх хөрөнгө зуучлагчдыг мэргэшүүлэх, мэргэжлийн индексийг бий болгох, мөн мэргэжлийн эрх олгох сургалтыг сайжруулах хүрээнд санал солилцсон.

03

## ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан "Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам"-ын шинэчилсэн найруулгын төсөлд санал авахаар цахим хуудас ([www.frc.mn](http://www.frc.mn))-т байршуулсан.

01